



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/114

Есөнбүлэг

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн "Аймгийн 2024 оны төсөв батлах тухай" 71 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 50,000,000 (тавин сая) төгрөгийн эх үүсвэрээр санхүүжигдэх Алтай сумын "Баянцагаан" багт үүрэн холбооны сүлжээ суурилуулах ажлыг гүйцэтгүүлэх эрхийг Алтай сумын Засаг дарга (Д.Эрдэнэжаргал)-д шилжүүлсүгэй.

2. Төсөл арга хэмжээний ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийг 2024 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор боловсруулан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, журмын дагуу зохион байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнахыг Алтай сумын Засаг дарга (Д.Эрдэнэжаргал)-д үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэл, чанар, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ), Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг)-т тус тус даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2023 оны 05 дугаар сарын А/304 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ

C:\Documents\ ZDA4

8236310202

